



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/29

Хэрлэн сум

Иргэдэд мэдээлэл сурталчлах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.16, Эрүүл мэндийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг үнэлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим платформын хэрэглээг нэвтрүүлж, иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Өнөрцэцэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Т.Дөлгөөн	Иргэдийн төлөөлөл (Зөвшилцсөнөөр)
Гишүүд:	Г.Болд –	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлого зохицуулалт иргэд олон нийтийн хэлтсийн дарга (Зөвшилцсөнөөр)
	Г.Ариунхүү	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Цэнджав	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Оюун-Эрдэнэ	Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
	Ж.Алтансүвд	Эрүүл мэндийн газрын Өсвөр үе, нөхөн үржихүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Мөнхбаяр	Хэрлэн сумын 3 дугаар багийн Засаг дарга
	Т.Уранцэцэг	Ач манал өрхийн Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	Д.Батболд	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймаг дахь салбарын дарга (Зөвшилцсөнөөр)

2.

Г.Эрхэмбаяр	Өсвөрийн сэтгүүлч клубын зөвлөгч гишүүн (Зөвшилцсөнөөр)
Д.Мөнхчимэг	“Хэнтий Бриллиант” Төрийн бус байгууллагын тэргүүлэгч
Д.Байгалмаа	“Баян саран гүмүда” Төрийн бус байгууллагын тэргүүн
Н.Энхжаргал	“Амжилтын ташуур” Төрийн бус байгууллагын тэргүүн
Г.Ганчимэг	“Амжилтын ташуур” Төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал
М.Бямбаням	Иргэдийн төлөөлөл (Зөвшилцсөнөөр)
Ж.Сэр-Од	Иргэдийн төлөөлөл (Зөвшилцсөнөөр)

2.Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг бодитоор үнэлэх, цахим платформыг аймгийн хэмжээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга буюу Ажлын хэсгийн ахлагч (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ